



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/210

Улаанбаатар хот

Гамшгийг тэсвэрлэх чадавхыг
үнэлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам"-ын 3.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1402 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх" аргачлалын дагуу дүүргийн гамшгийн тэсвэрлэх чадавхыг үнэлэх ажлыг 2025 оны 10 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Гамшгийг тэсвэрлэх чадавхыг үнэлэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлгээ хийх ажлын хөтөлбөрийг 3 дугаар, шаардагдах зардлыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3."Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь" санаачилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, нөхцөл байдлын мэдээг цуглуулах, болзошгүй эрсдэлийг тодорхойлох ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулах, Ажлын хэсгийн гишүүдийг мэргэжил арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Г.Дагвадорж)-т үүрэг болгосугай.

4.Гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэхэд шаардлагатай 195,000 (зуун ерэн таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 15 ны өдрийн
17210 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн

ахлагч:

Гишүүд:

Г.Дагвадорж

Б.Болормаа

Дүүргийн менежер

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

ажлыг зохицуулах Салбар

зөвлөлийн нарийн бичгийн дарга

бөгөөд ажлын албаны дарга

Д.Хүрэлбаатар

Багахангай дүүргийн Засаг

даргын Тамгын газрын Хотын

стандарт, тохижилт, нийтийн аж

ахуйн хэлтсийн дарга

Ч.Магадсайхан

Газар зохион байгуулалтын

албаны дарга

О.Энхжин

Багахангай дүүргийн 1 дүгэр

хорооны нийгмийн ажилтан

У.Батжаргал

Багахангай дүүргийн 2 дугаар

хорооны бүртгэл, мэдээлэл

зохион байгуулалтын асуудал

хариуцсан ажилтан

Р.Баярсүрэн

Цагдаагийн хэлтсийн хэв журмын

ажил хариуцсан ахлах байцаагч,

ахлах дэслэгч

М.Мөнхболд

Онцгой байдлын хэлтсийн гал

түймрийн улсын хяналтын

байцаагч, ахмад

Д.Ундрал

Статистикч

Ш.Номин

Багахангай дүүргийн Эрүүл

мэндийн төвийн нийгмийн эрүүл

мэндийн ажилтан

Ч.Сансрайдорж

Илч-Орд ОНӨААТҮГ-ын инженер

Г.Отгончулуун

Багахангай тохижилт

ОНӨААТҮГ-ын инженер

С.Бат-Ирээдүй

Ус суваг ашиглалтын товчооны

технологич инженер

Д.Мөнхтөр

Налайх хэрэглэгчдэд үйлчлэх

төвийн Өндөр толгой хэсгийн

Монтер

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 13 ны өдрийн
А/210 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ГАМШГИЙГ ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ
ОНООНЫ АРГААР ҮНЭЛЭХ АЖЛЫН
УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1.1. "Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь" санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд НҮБ-ын гамшгийн эрсдэлийг бууруулах газраас гаргасан "Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх" аргачлалын дагуу нийслэлийн гамшгийг тэсвэрлэх чадавхын үнэлгээг хийж, эрсдэлийг тодорхойлж, зөвлөмж боловсруулан эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр. Үйл ажиллагаа

2.1. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, гамшгийн нөхцөл байдлын мэдээг цуглуулах

2.2. Ажлын хэсэг гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг боловсруулах, эрсдэлийг тодорхойлох, зөвлөмж гаргах

2.3. Ажлын хэсгийн гишүүд үнэлгээний аргачлалын дагуу холбогдох судалгаа, танилцуулгыг бэлдэж ирэх

Гурав. Үнэлгээний зохион байгуулалт

3.1. Танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана. НОБГ-аас арга зүйгээр хангаж, цахимаар холбогдож, нийслэл, дүүргийн үнэлгээний ажлын хэсэг танхимын хэлбэрээр ажиллана.

3.2. Нийслэлийн хэмжээнд оролцогчид тус санаачилгын хоёрдугаар үе шат буюу "Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот 2030" болон "Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх" аргачлалын тухай мэдээлэл олгох нэгдсэн сургалтад хамрагдана.

3.3. Оролцогчид 9 дүүрэг тус бүрээр бүлэгт хуваагдан "Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх" аргачлалын дагуу 10 үндсэн чиглэлийн хүрээнд үнэлгээ хийнэ.

3.4. Үндсэн 10 чиглэлийн дагуу үнэлгээг хийж гүйцэтгэсний дараа оролцогчид үр дүнг танилцуулан хэлэлцүүлж, тайлан боловсруулна.

Дөрөв. Хугацаа

4.1. Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтсийн сургалтын танхимд 2025 оны 10 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд болно.

----- оОо-----

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 13 ны өдрийн
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

ГАМШГИЙГ ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ
ОНООНЫ АРГААР ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН
ХӨТӨЛБӨР

Хаана: Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтсийн сургалтын танхим

Хэзээ: 2025 оны 10 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд

2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр		
Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах албан тушаалтан
08:50–09:00	Бүртгэл	НОБГ-ын Эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад Д.Нямдорж
09:00–09:10	Нээлт	НЗДТГ-ын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар
09:10–09:40	НҮБ-ын гамшгийн эрсдэлийг бууруулах газраас “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь” санаачилгын хоёр дугаар үе шатны танилцуулга	НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын Хөгжлийн зохицуулалт-Стратеги төлөвлөлтийн мэргэжилтэн, багийн ахлагч Ч.Ариунаа
09:40–10:20	“Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь” санаачилга, “Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх” аргачлалын дагуу 2018, 2022 онд хийгдсэн үнэлгээний үр дүн	НОБГ-ын Дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Ж.Төмөрмандах
10:20–10:30	Цайны завсарлага	
10:30–12:30	Суурь мэдээллийг танилцуулах	Оролцогчид
12:30–13:30	Өдрийн хоол	
13:30–14:00	“Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх” аргачлалын танилцуулга	НОБГ-ын Эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад Д.Нямдорж
14:00–15:50	Бүлгээр ажиллах: Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх үнэлгээний ажил /1, 2 дугаар үндсэн чиглэл/	Оролцогчид
15:50–16:00	Цайны завсарлага	
16:00–16:50	Бүлгээр ажиллах: Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх	Оролцогчид

	үнэлгээний ажил /3, 4 дүгээр үндсэн чиглэл/	
16:50–17:00	Асуулт, хариулт	Оролцогчид
17:00–17:10	Эхний өдрийн дүгнэлт, хаалт	НОБГ
2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр		
08:50–09:00	Нийслэл, дүүргийн Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг бүртгэх	НОБГ, дүүргийн Онцгой байдлын хэлтэс
09:00–10:20	Бүлгээр ажиллах: Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх үнэлгээний ажил / 5, 6 дугаар үндсэн чиглэл/	Оролцогчид
10:20–10:30	Цайны завсарлага	
10:30–12:30	Бүлгээр ажиллах: Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх үнэлгээний ажил / 7, 8 дугаар үндсэн чиглэл/	Оролцогчид
12:30–13:30	Өдрийн хоол	
13:30–14:30	Бүлгээр ажиллах: Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх үнэлгээний ажил /9, 10 дугаар үндсэн чиглэл/	Оролцогчид
14:30–15:30	Бүлгийн ажлын танилцуулга /нэг дүүрэг 5-6 минут/	Оролцогчид
15:30–15:40	Цайны завсарлага	
15:40–16:10	Үндсэн чиглэл тус бүрийн үнэлгээний үр дүнд суурилсан зөвлөмж, дүгнэлт боловсруулах	Оролцогчид
16:10–16:50	Үнэлгээний нэгдсэн дүн, зөвлөмж, дүгнэлт танилцуулах /нэг дүүрэг 5 минут /	Ажлын хэсгийн ахлагч
16:50–17:00	Дүгнэлт, хаалт	НОБГ

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 13 ны өдрийн
8/040 дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

ГАМШГИЙГ ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ ОНООНЫ АРГААР
ҮНЭЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Нэгжийн үнэ (төгрөг)	Хамрагдах албан хаагчдын тоо	Сургалт явагдах хоног	Нийт (төгрөг)
1	Цайны завсарлага (өдөрт 2 удаа)	2,500	15	2	150,000
2	Цэвэр ус	1,500		2	45,000
	Нийт дүн				195,000